

**Монгол хэлний “газар” гэдэг үгийн утга,
хэрэглээ, хорших ёсноос үүтгэн...**

Б. Пүрэв-Очир *

...Өлгий сайхан ууланд өвгөдийг тавьсан
газар
Үр ач нарын үржиж өссөн **орон**.
Таван хошуу мал тал дүүрэн бэлчсэн **нутаг**
Монгол хүн бидний сэтгэлийг сорсон **орон**.
(Дашдоржийн Нацагдорж)

Монгол хэл маань хоршоо үгийн арвин баялаг сан хөмрөгтэй, хоршоо үгийн найруулга, хэрэглээ үлэмж олон талтай. Монгол утга соёлд хоёроор эелдэн найрах хос ёсны зарчим их л нарийн ажээ. Морин хуурын чавхдас нь хоёр, морин тэрэгний арал нь хоёр, монгол гэрийн багана нь хоёр, монгол хоршоо үгийн бүтэц, хэм нь хоёр, монгол арга, билгийн ёс нь хоёр болой. Нэрт зохиолч Мишигийн Цэдэндоржийн “Морин хуур” шүлэгт:

... Хоёрхон чавхдасны эгшгэнд
Хорвоо юундаа уярнам бэ?
Буурал хорвоогийн түүхийг
Бум олны явдлыг
Холбож яаж дуулахлаараа
Хоёрхон чавхдасанд багтаана вэ?
... Хорвоогийн хамаг явдлыг
Хоёрхон чавхдасаар ярьдаг
Хосгүй нэгэн овог
Азийн цээжинд нутагтай...

гэж бичсэн бий. Энд “хоёрхон чавхдасаар ярьдаг”, “хосгүй нэгэн овог”, “Азийн цээжинд нутагтай” гэдэг хэллэгийг их сонин, өргөн утгаар нь онцолж хэрэглэсэн байдаг.

Ер нь, үүнээс үүтгээд, монгол хүн, хорвоо дэлхийн явдал суудал, шалтгаан ба үр, амьдрал тэмцлийг “хоршоо үг”-ээр өнгө зохилдуулж холбон найруулдаг, ярьдаг, бичдэг, харилцахуйн түвшин дэх үнэлэмж, сэтгэлийн зэрэг, сөрөг хөдөлгөөнөө илэрхийлдэг гэхэд нэг их хэтийдэхгүй юм шиг санагдана. Нэг хоёр жишээ татаад сонирхъё л доо.

* Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн профессор

Монгол улсын Соёлын гавьяат зүтгэлтэн, нэрт найруулгач, зохиолч Жамцын Бадраа гуайн “Их дуучны яриа”, (Уб., 2005) номд буй Улсын алдарт гавьяат дуучин Дугаржавын тэр их сайхан амьд сэрүүн **ярианы найруулгад** “хоршоо үг”-ийг хэрэглэсэн нь гайхмаар байна.

...Цэнджав бол **гарамгай сайхан** дуучин байсан. Би хоолойг нь эмчлүүлэх **арга чарга** байна уу, **гадаад мадаад** явуулъя, **Болгар Молгарт** явуулъя гээд **яам тамгаар** бишгүй л **хэлж ярьж** үзсэн, ер бүтээгүй... гэсэн өгүүлбэрт 5-6 удаа сонин сонин “хоршоо үг” хэрэглэжээ.

Монгол улсын гавьяат багш, профессор А.Шархүү докторын “Үнэнийг танин мэдэх Сократын бодол, зарчим” (“Ил товчоо” сонин, 1991, № 6) гэсэн **нийтлэлийн** найруулгад:

...**Байгаль дэлхий** хүнийг **өө сэвгүй** төрүүлэх нь **ховор живэр** болохлоор Сократ гадна байдлаараа **гоё сайхан** гэхээргүй хүн байж. Тэрээр **мэлийсэн бүлтгэр** нүд, **навшийсан навтгар** хамар, **дарвагар зузаан** уруул, биедээ томдсон **халзан мулзан** толгой, **богинохон агдгар** хүзүү, **цүрдгэр цондгор** гэдэстэй, **намхан болцгор** хүн байсан аж... гэж бичсэн байдаг. Энд тэр их агуу ухаантан, эгэл энгүүн хүн - Сократын гадаад байдлыг илтгэн дүрслэхэд “хоршоо үгс” ямар их чухал үүрэг, өнгө аястай орж, найруулгыг дүрслэг болгосныг уншсан хэн хүн мэдэрч болохоор байдаг...

Одоо их зохиолч Д.Нацагдоржийн **урансайхны** найруулгад “хоршоо үг”-ийг ёстой нэг оновчтой сайхан хэрэглэсэн тэр олон жишээнээс нэг хоёрыг татаад харъя.

“**Үзэгдээгүй юм**”-д:

...**Орчин тойрон** зэргэлсэн уулс **бэрх өндөр**, сэрвэн хад нь **сэхийлцэн сахайлцан, сүр жавхлан** хэтэрхий, **ой шугуй** нь **нягт зузаан**, усан булаг **хоржигнон хуржигнана**, **хавцал хаднаас** асгарах **хархираа хүрхрээ** цөмөөр Идэрийн гол дор цутгах бөгөөд түүний цэнхэр уснаас уухуй дор дотор **сэнгэнэн сэргэнэ...** гэж;

“**Шувуун саарал**”-д:

...Харийн хошууны нутаг дор орохуйяа урьд үзэгдээгүй **уул усан** бас ч сонин. **Үүгээр түүгээр**, **адуу мал** зөндөө бэлчээд, **үе үе** тохиолдох айлын зэл дээр бариатай гүүнүүд янцгааж, **айраг найрын** цаг мэдэгдэвч, **дайран орж**, **зугаацан цэнгэх**, **зав чөлөө** хаана... гэж байдаг. Урансайхны дүрслэлд хоршоо үг ямар чухал үүрэгтэйг эндээс харж болохоор байна.

Эрдэм шинжилгээний найруулгад, Монгол улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, нэрт эрдэмтэн, профессор Лхамсүрэнгийн Хүрэлбаатар агсны “Огторгуйн цагаан гарди” (Уб., 1996) номд буй өдий төдий жишээ баримтаас “хоршоо үг”-ийг гойд тансаг, эелдүүлэн хэрэглэсэн олон тохиолдлоос нэгээхэн хэсгийг татаж харахад тодорхой болно. Үүнд: “Эсэруагийн залуу хөвгүүнийг мөшөөлгөсөн нь” хэмээх хэсэгт:

“...Иймээс ч Жамъянгарав, оюун ухааны егүүтгэлийн эцэст түймрийн **ор мөр** дээр **цэцэг ногоо** ургах мэт **ном ухаан** дэлгэрэн, гэгээ нь арилсан нүд, хараа орох мэт **билэг авьяас** нээгдэн, **хатаж ангасан** загас уснаа учрах мэт **хүсэл ерөөл** бүрдсэн, **од гараг** хоёр, **шороо**, **ус** нийлэлдсэн мэт **орь залуу**, **идэр дэлгэрийн учрал ерөөлтэй** өдрийг сонгон авч, номоо төгсгөжээ. Монгол орныг мунхгийн балар нойрноос сэрээн дуугардаг өглөө бүрийн **ном эрдмийн** цагаан дунгийн дуун тасалдаж, **билиг оюуныг гийгүүлэн гэрэлтүүлэх** зулын гэрэл бөхөж, хошуу бүрийн хүрээ, жалга бүрийн дацанг **хайлуулан түймэрдэж**, эрдэмтэй бүхнийг **эрэг гангын** ирмэгт тулган, буун дуу тачигнуулж, **гэсгээл цээрлэлийг** оногдуулан, цөллөгийн газар руу гинжлэн тууж, **гаслан зовлон**, **гай гамшигт** живсэн төмөр нүүрт, цусан мөрт тэр жилүүдэд номын бор

гэлэнгийн утаат хөвхөн авдарт сэмхэн нуугдаж үлдсэн “Эсэруагийн эгшиг дуун” хэмээх эл номын шидэт үр нь **цаг хугацааны** хөрсөн дор хадгалагдан...” гэж бичсэнээс үзвэл, бидний сонирхож буй нөгөө “хорших ёс”-ыг даан ч сайхан баримтлан, найруулсан нь бэлхнээ тодорч байна.

Монгол хэлэнд “айл аймаг”, “ааш зан”, “атаа жөтөө”, “айраг найр”, “айдас хүйдэс” г.м. “А” толгойт хоршоогоос эхлээд л “уул ус”, “уул нуруу”, “уул овоо”, “уул толгод”, “уул ухаа”, “сээр нуруу”, “нуруу туруу” г.м.-ээр өгсүүлэн, “янз маяг”, “яс мах”, “ял зэм”, “янз маяг”-ийг хүртэлх “Я”-толгойт хоршоог дуустал төрөл бүрийн найруулгаас бүрэн шүүрдэж, уг гарвал, утга санаа, бүтэц бүрэлдэхүүн, амь амьдрал, эрчим долгион, соёл хэрэглээнд нь элдэв янз хайлт хийвэл, их сонин юм гарна, тэр чанараараа багагүй ач холбогдолтой байж болно.

Хэлний биш, өөр өөр ажил мэргэжлийн хүн ч гэсэн, сонирхоод шохоорхоод үзвэл, нээрээ “айраг найр”-(-ын цаг), “нуруу туруу”-(-нь тэгш сайхан), “нутаг газар” (-нь гайхалтай) гээд л энэ хос үгс ямар учиртай хоршив, хэн, яаж хэрэглэв гээд л үзэхлээр гайхмаар, биширмээр, танин мэдмээр байдаг.

Монгол хэлэнд “газар”, “шороо”, “нутаг”, “ус”, “өлгий”, “орон”, “байр”, “гэр”, “хот”, “хээр”, “хөдөө”, “суурин”, “балгас”, “байгаль”, “дэлхий” г.м. үгс утгын нэг оронд орчиж, багцарч байдаг. Тиймээс ч “газар шороо”, “газар орон”, “газар дэлхий”, “газар гэр”, “суурин балгад”, “гэр орон”, “хот суурин”, “орон байр”, “хөдөө хээр”, “хөрс шороо”, “байгаль дэлхий”, “нутаг ус”, “газар нутаг” г.м.-ээр хоршин хэрэглэгддэг.

Монгол хэлний “газар” гэдэг үгийн олон салаа утга, энэ үг бусад үгтэй яагаад хоршин хэрэглэгддэг вэ? Түүний хоосон чанар, танин мэдэхүй, хэл соёл, хэрэглээний талыг ажиглаж нягталбал сонин содон мэдлэг-мэдээллийг гаргаж болох талтай юм. Дэлгэрэнгүй тайлбар толь сөхөж үзвэл, хамгийн олон салаа утгатай, машид олон нийлэмж үүсгэсэн үг бол монгол хэлний **“газар”** гэсэн үг байна. Үүнийг утга зохиолын баримтаар нотолж болно.

Урансайхны, ярианы, сонин нийтлэлийн, албан хэргийн, эрдэм шинжилгээний найруулгад **“газар”, “шороо”, “орон”, “нутаг”** г.м. үгсийн ялгааг гаргаж, утгыг таньж хэрэглэхийн учир нарийн бөгөөд дээрх үгсийн утга учрыг олж, өнгө аясыг нь зохицуулж, эелдүүлэн хоршиж хэрэглэнэ гэдэг монгол хэлийг сурч буй гадаадын (харийн) хүнд байтугай, эх хэлээ тээгч зөөгч монгол хүнд ч яггүй ажил байдаг хэмээн үзэж болно.

Хуучин Монгол шинэ Монгол болохын шувтарга үес, Хуучин хүү шинэ хүү болохын эхлэл цаг, Хөх монгол Улаан монгол болохын угтал орчил, хуучин уранзохиол шинэ уранзохиолоор дэвшин хөгжихийн түрүүч үед өөрийн олон сайхан зохиолд “эх орон”, “эх хэл”, “үндэсний соёл”, “газар”, “нутаг”, “өлгий”, “шороо”, “хөрс” г.м. монгол хэлний үг -утгын сангийн хойморт заларч байдаг утга гүн, эрчим энергитэй энэ үгсийг давтагдашгүй сайхан, анх түрүүнд, ёстой нэг онож, эелдүүлэн найруулж хэрэглэсэн зохиолч бол их Нацагдорж мөн. Түүний наад захын баримт жишээ нь монгол хүн бүхний сайн мэдэх:

Өсөхөөс сурсан үндсэн хэл

Мартаж болшгүй **соёл**

Үхтэл орших төрөлх **нутаг**

Салж болшгүй **орон...** гэдэг дөрвөн мөрт шүлэг, цаад захын жишээ бол амьдралынхаа сүүлчийн жилүүдэд (1934) туурвисан “Хэлхээ үгүй сувд” хэмээх туужийнхаа “Хаврын цэцэг” гэдэг нэгдүгээр бүлэгт бичсэн:

“...Нэгэн мянга есөн зуун нэгэн (Бадруулт төрийн 26 дугаар он) он, хуучин улирлын машинд арилсны 15 дугаар жарны үхэр жилийн цагаан сарын арван тавны өглөө Богд хан уулын дорнодоос үүрийн хаяа цайран гарахуй дор эргэн тойрон олон уулын хяр хянгын цасан мөсөн гилтгэнэхүйн дунд бөөн бөөн уур савсан, **халх нутгийн** бүлээн зүрх энд буй хэмээн...” гэдэг өгүүлбэрт байгаа “**нутаг**” гэдэг өргөн утгат үг болно. Д.Нацагдоржийн зохиол дахь “халх нутаг” гэдэг үлэмж үнэ цэнтэй үг бол их зохиолчийн амьдралынхаа сүүлчийн жилүүдэд зохиол бүтээлдээ бичиж үлдээсэн түүхэн баримт болно.

Их зохиолчоос хойш залгаад л монгол “эх орон”, “эх хэл бичиг”, “үндэсний соёл”, “газар”, “шороо”, “нутаг”, “эх дэлхий”, “нүүдэлчид” г.м. үг-утгыг Б.Ринчен, Ц.Дамдинсүрэн, Д.Сэнгээ, Ц.Цэдэнжав, Ч.Чимэд, Л.Түдэв, Д.Пүрэвдорж, Ж.Бадраа, Ц.Гайтав, Н.Нямдорж, Р.Чойном тэргүүтнээс өгсүүлээд л, Д.Цоодол, Ш.Сүрэнжав, П.Бадарч, Ш.Дулмаа, М.Цэдэндорж, Д.Нямаа, Д.Нямсүрэн, О.Дашбалбар, Б.Лхагвасүрэн, Д.Маам, Д.Урианхай, Ц.Чимэддорж, Т.Очирхүү, З.Түмэнжаргал, Б.Доржпалам, Ч.Мягмарсүрэн, Г.Мэнд-Ооёо, Ш.Гүрбазар, Х.Чилаажав, Ү.Хүрэлбаатар, Ц.Бавуудорж, А.Эрдэнэ-Очир, Ц.Хулан, Г.Мөнхцэцэг, Б.Ичинхорлоо, Ш.Лхамноржмаа, Д.Алтангэрэл, Б.Баярсайхан, Ш.Билигсайхан, М.Билэгсайхан, Дарь Сүхбаатар, Л.Мягмарсүрэн, П.Нямлхагва, Ай.Төмөр-Очир гээд хэдэн арваар тоологдох зохиолч-найрагч нар янз янзаар хэрэглэж, өвөрмөц сонин “хоршиж” найруулсныг зохиолынх нь баримтууд харуулж байна.

“Эх орон”, “нутаг”, “газар” г.м. үг-утгын нэгжүүдийг дангаар болон “хоршоо”-гоор хэрэглэсэн тийм сайхан дүрслэлтэй, найруулгатай эх-бичвэрүүдэд Д.Нацагдоржийн “Миний нутаг”, Ц.Дамдинсүрэнгийн “Монгол нутаг”, Ц.Цэдэнжавын “Миний нутаг”, Ж.Бадраагийн “Халуун элгэн нутаг”, Ц.Гайтавын “Сайхан эх орон”, Ч.Чимидийн “Эх орон”, Д.Сэнгээгийн “Эх орон”, Д.Цоодолын “Эх орон минь хүмүүс юм”, Ш.Дулмаагийн “Эх орон”, Б.Лхагвасүрэнгийн “Монголын их хээр тал”, П.Бадарчийн “Есөн эрдэнийн орон”, Д.Урианхайн “Эх орны тухай бодол”, З.Түмэнжаргалын “Монголын тал нутаг”, Д.Маамын “Газар шороо”, Ц.Чимэддоржийн “Сууж байхдаа ч нүүж явдаг монгол”, Д.Нямсүрэнгийн “Дөрвөн цаг”, Т.Очирхүүгийн “Аргамжааны чулуу”, Ш.Гүрбазарын “Би монголоороо гоёдог”, Б.Доржпаламын “Тарааж цуглуулсан эх орон танаа”, Х.Чилаажавын “Эх орон”, Г.Мэнд-Ооёогийн “Хэсэг цагаан манан”, А.Эрдэнэ-Очирын “Хөндүүр зүрхний эх орон”, Ц.Бавуудоржийн “Монголын их амар амгалан”, Г.Мөнхцэцэгийн “Чамаас олсон эх орон”, Ц.Хулангийн “Эх орон Танаа”, Б.Ичинхорлоогийн “Эх нутаг”, Ш.Лхамноржмаагийн “Миний эх орон-миний үр орон”, Д.Алтангэрэлийн “Эх-орон”, Б.Баярсайханы “Газар шороо минь”, М.Билэгсайханы “Тэгээн Монгол”, Н.Гантулгын “Эх орон”, Э.Гантулгын “Эх орондоо хэлэх үг”, П.Нямлхагвагийн “Дөрвөн цагийн эх орон”, Х.Сүглэгмаагийн “Эх орон”, Бя.Энхтуяагийн “Мөнх тэнгэрийн бошго”, Л.Эрдэнэбатын “Эх орон” г.з. олон зохиол бүтээлээс “эх орон”, “өлгий нутаг”, “нутаг”, “газар”, “шороо” тэргүүтэн үгсийг хэрэглэсэн соёл, сэтгэлгээний онцлог, хоршсон ёс, уламжлал, шинэчлэлийг харж болмоор байна.

“Эх орон”, “эх нутаг” гэдэг өргөн утгын дотор багтааж, “газар” гэдэг үгийн утгыг салаалуулан, эн түрүүнд гайхалтай зөв ухаарч, хэрэглэсэн зохиолч бол их Нацагдорж

юм. Их зохиолч Д.Нацагдорж, яруу найргийн болон хүүрнэл зохиолууддаа “газар” гэх үгийн утгыг салаалуулан 60 гаруй удаа машинд өвөрмөцөөр хэрэглэсэн бий. Монгол хэлний “газар” хийгээд “тэнгэр” гэдэг үг нь эсрэгцэж, арга, билгийн талаасаа машинд өргөн утга заах авч, хэрэглээ-соёлын хүрээнд орохлоор “газар”-аас нь харьцааны олон утга салаалан сацардгийг “Нацагдорж”-оос харж болно.

Их зохиолчийн бүтээлүүдэд “газар”, “орон”, “нутаг” гэх үгсийг дангаар нь, эсвэл хоршиж, аль эсвэл, нэршсэн нийлмэл үгийн хэлбэрээр машинд оновчтой, 40 орчим удаа хэрэглэсэн сонирхолтой зохиол бол “*Берлин явсан замын тэмдэглэл*” (1927) юм. Энэ жишээ-баримтыг дэлгэн харж, бас утгын ба соёл-хэрэглээний талаас нь тандалт, хайлт хийж ажиглавал сонин байна. Үүнд:

[...] Урагш хэдэнт шогшиж, замыг дөхөөн,
Хойш хэдэнт харж, **хот орноо** санагалзан яваа...;
[...] **Хээр хөдөөгийн газар** нэгэнт болоод,
Уул усан жигдлэн, өвс ногоо үргэлжилнэ...;
[...] Хөндлөн гулд уудам **талбар газар** бөгөөд
Хуучны долоон хошуу наадам бужигналдана...;
[...] Бидний Монголын **тариалангийн газар** энэ орчимд болж
Улмаар хөгжүүлбээс ардын амьдрал дор тустай...;
[...] Хараагийн өртөөнд очоод, ажиглаж үзвээс
Газрын байдал, уул усан нь жигдэлжээ...;
[...] Аяа, уудам сайхан **хөдөөгийн газар** хэмээгч
Нүүдэлчин монгол хүний сэтгэлийг булаана...;
[...] Хязгаарын **боомтын газар** хялбар нэвтрүүлсэн боловч,
Гаалийн газар байцаан нэгжих нь яршигтай...;
[...] Явах зам Буриад **монголын нутаг**,
Байдал төлөв нь **Монгол газрын** ойролцоо...;
[...] Оройн бүрийгээр шаардан давхисаар
Удалгүй **Өвгөн хэмээх газар** хүрч буудаллав...;
[...] Их гудамжны амсар дээр монгол нөхөд лугаа учралдан ярилцаад,
Төдөлгүй нэгэн **буудлын газар дор** буув...;
[...] **Газар орон** нь үзэсгэлэнтэй сайхан,
Энэ этгээд дор их нуур хязгааргүй цэлмийж...;
[...] Нөгөө этгээд дор уулс ханарсан нь
Үнэхээр сонирхом **хүсэлтэй газар** болой...;
[...] **Өртөөний газар** буудаллах илдар аа,
Хотын захыг сонирхон үзэв...;
[...] Өдөр шөнөгүй явсаар авч, **газрын дунд** болоогүй,
Урт замын уйтгар хөдлөн ядна...;
[...] Сибирийн хязгаар уудам их агаад,
Шилмүүст нарсан модоор бүрхсэн **нам газар** ажгуу...;
[...] Гурав дөрвөн хоног болж, **газрын дунд** ирвээс,
Үргэлж ойт **нам газраар** явсаар амой...;
[...] Киргизийн тал, уужим тэнүүн болох нь
Монголын **говь газар** адил байдал амой...;
[...] **Сибирийн орны** гол хот бөгөөд,
Мөн ч үймээн, **хөл ихээхэнтэй газар** болой...;

[...] Зүүн **Европын газрын** байдал нь
Сибирийн хязгаар лугаа төлөв ойролцоо бөгөөд...;
[...] Баятка (Вятка) хотон дор ирээд үзвээс
Бага сага сонин **худалдаа дэлгэрсэн газар** буй...;
[...] Урьдын суусан танил хот болох тул
Олон монгол овогтны Буддагийн **сүмийн газар** суув...;
[...] Түүгээр үүгээр сэлгүүцэн явахуй дор дасамгай агаад,
Тавтайяа хуучин **нутагтаа** ирсэн мэт амой...;
[...] Их Невагийн хөвөөн дээр очиж,
Гааль ба хилийн газар байцаалган үзүүлэв...;
[...] Зургадугаар өдөр болохуй дор **газар** ойртсон бөгөөд
Онгоцны явдал нэлээд зөөлөн болов...;
[...] Гэтэл тэр дор **хуурай газар** үзэгдэж,
Хуучин, шинэ танил нөхөд учирсан адил амой...;
[...] Герман улсын хязгаар дор нэгэнт иржээ.
Газар орон, хүн ардын байдал сонин болов...;
[...] Бас **Өртөөний газар** очиж, тэрэгний пиу аваад,
Нэгэн **буудлын газрыг** олж хонов...;
[...] Эндээс нэгэн **газарчин хүнийг** олж явсаар

Монголчуудын **суусан газрыг** олж очив... г.м. баримтууд болон бусад зохиолын тооцоо сэлтээс гаргалгаа хийхэд дараах хэдэн утга зонхилж байна гэж үзэв. Үүнд:

а) Ямар нэг нэртэй газар, орших нутаг дэвсгэр гэсэн утгаар, жишээ нь: Би энэ **газар** өсөхөөсөө аваад, өтөлтлөө суусан бөгөөд угаас гөрөөчин хүн тул, ойр хавийн **газрыг** бараг мэднэ. Тийм нэртэй **газар** сонссон нь үгүй... (“Харанхуй хад”); Энэ жил зуд турхантай болоод, ойр хавийн чинээлэг айлууд аль өнтэй **газрыг** эрж, ...нүүдэллэн одохуй дор... (“Үүрийн жавар, уурын чимээ”);

б) Байршил, зүг чигийн утгаар хэрэглэсэн нь: Алтан дэлхий уудам их, **аль газар** “Харанхуй хад” хэмээгч байхыг хэн, яаж мэднэ...; Балгармаа ...гэр орондоо одохыг орхиж, мэдэх **газар, усны** нэрийг цэргийн дарга нар дор хэлэх ба айх эмээхийг умартаж, даруй **байлдааны газраа** буугийн дуун сонсохыг хүсэн одно... (“Үзэгдээгүй юм”);

в) Нутаг-орон хол зайдуу гэх утгаар, жишээ нь: Хөдөө талын зэрэглээ мяралзан жирвэгнэхийн дунд хэдэн өдөр юм сүүмэлзэн үзэгдэх нь **харь газрын** аяны хүний нүдэнд яахин даруй танигдана. (“Хөдөө талын үзэсгэлэн”); Шар бажгар дурдан бүсийг шавхийтэл ороогоод, угалзтай шөнтгөр гутлыг дөрөөний дунд тасхийтэл жийсэн нь талын идэр махбодыг бахархуулжээ. **Харь газрын** залуу хүн би, түүний замыг хөндөлсөн саатуулж, хэдэн үг хэлэлцэхүй дор **тал газрын** бага охин тэрвээр, жолоог татан, дуртайгаар түдгэлзэн хариулан өчиж, басхүү энэ тэрийг лавлан сонирхоно... (“Хөдөө талын үзэсгэлэн”);

г) Баримжаа хэмжээ талбай, орон зайн хэмжээсийн илэрхийлэл заах утгаар, жишээ нь: Сүрэнхүү, шувуун саарал хоёр, **хоногийн газрыг** өдөрт хүрэхийг ихэд чармайн, тэмүүлэн хатирна... (“Шувуун саарал”); Солгой Даржаа үүнээс даруй ухаан орж, хөлсний морин тэргийг гуйн суугаад, өтөлсөн өвгөн тэнхээтэй болж, өдрийн **өртөө илүү газар** хатируулсаар, хоёр хоноод **хийдийн газар** хүрэв... “Үүрийн жавар, уурын чимээ”;

Хавар, намар хоёр

Хүний сэтгэлийг хөдөлгөнө.

Ногооны униараар

Хол газраас морин

Нутагтаа гүйнэ. (Сул шүлгээс) г.м. Энэ тохиолдолд саахалтын газар, хурга ишиг нийлэх газар, өдөрчийн газар, хоногийн газар, сарын газар, айл саахалтын газар, алга дарам газар, өртөө газар, зуун бээрийн газар г.м.-ээр тогтвортой нийлэмж үгсийг хэрэглэдэг. Д.Нацагдорж, ийм үгсийг гайхалтай сайн мэдэрч, зөв хэрэглэсэн байна.

д) Ийм тийм улс, орон, гүрэн, үндэстэн гэх тохиолдолд, жишээ нь: **Энэтхэг газрын** эрдэнийн хормогчоор доод биеийг чимсэн, эрүүл сайхан цээжин биеийг ил гаргаж, гайхуулсан... (“Энэтхэг бүсгүй”);

Алс газар аа сурахаар одох замд

Намрын салхи өмнөөс сэрчигнэнэ...

Хээрийн галуу нисэн үл хүрэх газраас

Хүний хөвгүүн тийнхүү эрдэнэ өвөртөлж харина (“Алс газар аа сурахаар явагч”);

Олон хүүхэд угтан гарч гүйлдэхийг үзвээс,

Цөм боловсон улсын хувцасыг өмсөж, байдлыг олжээ.

Харилцан амар мэндийг мэдэлцэн орж, суугаад,

Тэр нутаг зүгийг сонирхон, бас **энэ газрыг** сонирхоно...

Энэ газар сууж, эрдэмд боловсорч, улс ард дороо туслахаар зорив... (“Берлин явсан замын тэмдэглэл”);

е) Ямар нэгэн үйлчилгээ үзүүлэх байгууллага, албан байр гэх оноосон нэрийн утгаар, жишээ нь:

- Энэ ямар **газар буй** хэмээн үүдэн дэх хүнээс асуувал,

- **Эрүүлийг хамгаалах газар** гэнэ.

- Яадаг **газар** буй хэмээвээс,

- Өвчтэй хүнийг эдгээдэг **газар** хэмээнэ. (“Хөгшин хүний өгүүлэл”); Жич, Нацагдорж зохиол бүтээлдээ **“нялхсыг хамгаалах газар”, “сургууль боловсролын газар”, “хүмүүжлийн газар”, “сувилах газар”, “сургуулийн газар”, “байцаах газар”,** г.м.-ээр олон янз тохиолдолд хэрэглэсэн нь сонин.

ж) Хүн ба мал амьтны бие эрхтний хэсгийг заах (талбайн) утгаар, Жишээ нь: **Хуарын хамар хэмээх газар,** гурван зуун жаран таван хоног турш их хүчтэй байлдаан болж... (“Аюулт байлдаан, сүрт тулалдаан”) г.м.

з) Бүхлийн хэсэг, тус газар буюу аль нэгэн тухайн орон зай гэсэн утгаар: Жишээ нь: Хөндлөн гулд уудам **талбар газар** бөгөөд хуучны долоон хошуу наадам бужигналдана, (“Берлин явсан замын тэмдэглэл”-ээс); Гурав дөрвөн хоног болж, **газрын дунд** ирвээс урт замын уйтгар хөдлөн ядна. г.м. (мөн зохиолд); (Жич: Энэ утга Д.Маамын “Газар шороо” романд “зуузайн тус газар”, “зүүн өвдгийн тус газар”, “өвдөгний тус газар”, “санчигний тус газар”, “үүдний тус газар”, “цээжний тус газар” г.м.-ээр тэмдэглэжээ.)


Их зохиолч маань эх хэлнийхээ **“газар”** гэдэг үгийг бодтой, тодорхой, ийм олон салаа утгаар, бас нэршсэн нийлмэл үгийн хэлбэрээр хэрэглэсэн бол, харин **“нутаг”** гэдэг үгийг үлэмж өргөн хийсвэр, ерөнхий, “эзэмшихүй”, “сахихүй” гэсэн утгаар нь цөөвтөр удаа оноож хэрэглэсэн. Түүний тодорхой жишээ бол алдарт **“Миний нутаг”** (1933) шүлэг юм. Д.Нацагдоржийн шүлэг зохиолуудыг ажиглаваас “Тэмдэглэлийн дэвтэр дэх сул шүлгүүд, үлдсэн мөр бадгууд”, “Бинтлэн цохворлосон зүйлс” нь яв

явсаар монгол “газар”, “орон”-оос “Миний нутаг”-т шилжин, нэгэн сайхан, хэдэн цогц бүтээл болсон юм шиг харагддаг.

...Атар баялаг Монголын **нутаг**
Агудам (уудам) сайхан дор
Хүн бүхэн талбиу талбиу амьсгаална...;
Монгол газар минь уудам юм шүү дээ
Маш сайхан газартай юм шүү дээ
Морио унаад давхихад
Манай цог заль бадардаг шүү дээ;
Хавар, намар хоёр
Хүний сэтгэлийг хөдөлгөнө.
Ногооны униараар, **хол газраас**
Морин нутагтаа гүйнэ.
Модны навчис зулзагарах
Намрын салхинд
Хол газраас, хүн

Гэр орноо мөрөөднө... гэх мэт мөр бадгууд нь “Эх орон”-ы сэдэвтэй хэд хэдэн зохиолын сэдэл санаа, үүтгэл болсон байдаг.

Нацагдорж, байгальлиг нэгдмэл орон зайн хүрээнд юу юуг “газар” гэдэг нэгж-утгаар, юу юуг “нутаг” гэдэг үг-утгаар илэрхийлсэн бэ? гэдгийг “Миний нутаг” шүлэг хэлж байна. Их зохиолчийн ойлгож, “Миний нутаг”-т хэрэглэж дүрсэлснээр бол:



Эндээс харахад, монгол нүүдэлчдэд “нутаг” гэдэг үгийн утга нь “газар” гэдэг үгийн утгаас илүү хийсвэр, олон талтай, олон зүйлийг өөртөө агуулсан байдаг бөгөөд орон зайн утгаараа ертөнц-дэлхий-орон-газар-нутаг-шороо-өлгий-өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржаа г.м.-ээр утгын орон, соёл, хэрэглээ, үнэлэмжийн ялгаа гарчээ. Дээр дурдаж буй энэ үгс хорших шинжээрээ ч, чимэг тодотголыг өөртөө хүртээн авч, дэлгэрэх шинжээрээ ч ялгаатай хэрэглэгддэг нь харагдаж байна. Нэгдмэл орон зайн дотор бичил орон зайг зааж илэрхийлэх үгс ч “орон”, “газар”, “нутаг” г.м. үг-утгад хамааралтай болдог тийм зүй тогтол байна. Үүнд холбогдуулан, Д.Нацагдоржийн

“Миний нутаг”-ийг Ц.Дамдинсүрэнгийн “Монгол нутаг”-аар улам батлан баяжуулан харж болно гэж үзэв. Үүнд:

Цагаан цасан **малгайтай**
Ногоон модон **хүрэмтэй**
Хөх усан **хормойтой**
Баян Хангай **уул минь.**
Маш дэлгэр **Хангай минь**
Мал сүргээр дүүрэн.
Малчин олон монголчууд
Жаргал цэнгэлээр дүүрэн.
Алаг цэцгийн **хөнжилтэй**
Алтан эрдэнийн **хэвлийтэй**
Атар хээр **нутаг минь...** гэж бий.

Энд “нутаг” гэдэг ерөнхий, хийсвэр, хөдлөнгө орны дотор “уул”, “хангай”, “малгай”, “хүрэм”, “хормой”, “хөнжил”, “хэвлий” г.з. бичил орон харьяалагдаж байгааг харж болно.

Тэгээд нэгдмэл орон зай гэдэг ойлголтын дотор, утгазүйн нэг талбарт орж буй үгс, харьцааны утга зааж, янз бүрийн нийлэмжийг үүсгэж, захирах-захирагдах харьцаа холбоонд орохдоо ойролцоогоосоо, эсрэгээ хүртэл нэг нь нөгөөг түшиж “хоршиж” бүтэх, хэрэглэгдэх тийм чадамжтай болдог. Монгол хэлний “газар” гэдэг үг нь “хөтлүүр үг”-ийн үүрэгтэйгээр орж,

газар дэлхий
газар шороо
газар нутаг
газар орон
газар байр
газар ус
газар лус
газар сай (гүй)
газар мазар

газар тэнгэр г.м.-ээр хорших бөгөөд “газар тэнгэр” бол энэхүү “хоршоо”-гийн эгнээний хоёр захыг хааж буй эх сэдвийн эсрэг утгат, арга, билгийн хоршоо үг болдог төдийгүй хамгийн их эрчим долгион хуримтлагдах ёстой “хоршоо”-гийн эгнээний туйл нь болно.

Энд “газар” гэдэг “хөтлүүр үг”-тэй хоршоогийн даял тойрууд “тэнгэр” гэдэг үгтэй хорших тохиолдолд ончрол үүсэж, цагариг хаагдаж, зогсон, тэг цэгтээ тулж байна гэж үзэв. Энэ тохиолдолд “газар”, “тэнгэр” хоёр бол синонимын эгнээний захын хоёр гишүүн болж, цаашид “эсрэг үгс”-ийн хоршоонууд нь эгнээ үүсгэн салаалах тийм зүй тогтолт болохыг харуулж байна. Харин “газар мазар” гэх дуурайн хоршоо үг үүсэнгүүт хоршоогийн даял тойруугийн эрч нь суларч, тойруу нь “О” цэг рүүгээ ойртож буйн дохио болдог гэж үзэв. “Газар” хэмээх үг ойролцоо утгатай бусад үгтэй хоршихлоороо илүү өргөн утга, олон талтай болно. Жишээ нь: “**Газар дэлхийг** доргиосон хүлэг морьдын төвөргөөн дундаас эзэн Чингисийн буурал сахал намилзан, мөнх хөх тэнгэрийн дэлгэц дээр цаст Алтай шиг тодорно.” (О.Дашбалбар, “Чингисийн амьсгалах нь сонстоно” өгүүлсэн шүлэг), **Ертөнцөд** их мэргэд олон төрсөн гэх авч, тэдний дотроос Нагаржуна, оддын дундахь саран адил гэрэлтэй. ...Түүний төрсөн он цаг, **газар**

ус нь яг таг тодорхой бус ч, Энэтхэгийн Өмнөд **нутагт** Видарба хэмээх **газар оронд** төрсөн гэнээ. (О.Дашбалбар, “Нагаржуна богд буюу нууцын чанад нэвтрэгч”-ээс), Монголчуудын байгальшил, ухамсарт байгаа **байгаль дэлхий** бол тэнгэрийн хишиг, газрын буян юм. Тэдний ой ухаанд **газар шороо** бол тэнгэр заяат “Этүгэн эх” байж, хэн нэгэнд өмчлөгдөн харьяалагдах юм биш, харин түүний ивээл соёрхлыг хүмүүс “**нутаг**” гэж таньж, хайрлан хамгаалж, үе дамжуулан амьдардаг байж. Нутгийн **газар шороо** бол тэр **нутаг** дээр аж төрөн суугаа хүмүүсийн хамаг эрх, дархан хамтын өмчлөл байж. Энэ нутгаас тэр нутаг, хуучин нутгаас шинэ нутаг, **нутгаас нутагт** нүүх нь нүүдэл соёлын тогтоц буюу хэвшил болно. “Нутаг солих” гэдэг үг эрт үүссэн бололтой. Монгол зүйр цэцэн үгэнд: “Малгай тавибал манай **нутаг**, маргааш явбал танай **нутаг**” гэж байдаг. Энэ нь **газар шороог** өөрийн юм (хувийн өмч) болгож байгаагүйг харуулж байна... (Буянбаатар, “Нүүдэл аж ахуй хийгээд нүүдэл соёл дахь байгальлиг шинжийг хайн судалсан нь”) гэх мэт наад захын жишээнээс ажиглахад, “**байгаль дэлхий**”, “**газар дэлхий**”, “**газар ус**”, “**газар орон**”, “**газар шороо**” гээд л хоршихлоороо хэлбэр-бүтэц, утга санаа, үүрэг-мэдээллийнх нь агуулга багтаамж тэлдэг, өгүүлэгч ба бичигчийн үнэлэмж, баймж, хандлага нь хоршоо үгэндээ илэрч шингэдэг, бодтой ба хийсвэр, тодорхой ба ерөнхий, ганц ба олны утгыг цогцлоодог тийм онцлог зүй тогтолтой байдаг гэж үзэж болмоор байна. Бас дээрх мэт жишээнд нэг тохиолдолд “**газар**” гэдэг үг нь, “**нутаг**” гэдэг үг нь дан, нөгөө тохиолдолд “**газар дэлхий**”, “**газар орон**”, “**газар нутаг**”, “**газар ус**” гэж хослон хоршин хурж бүтсэн байна. Энэ бол “хоршоо үг” ба “хорших хослох ёс” нь хоосон чанартай, хувирамтгай болохыг харуулж буй юм. Өөрөөр хэлбэл, “газар, дэлхий” хоёрыг, “газар, нутаг” хоёрыг, “газар, орон” хоёрыг, “газар, ус” хоёрыг хоршин хурж үйлдэхлээр бодтой, үзэгдэх дүрстэй болж, тэгснээ салгаж, “газар”, “дэлхий”, “нутаг”, “ус” г.м.-ээр нэг нэг, тус тус болгож хэлж хэрэглэвэл энэхүү “хоршоо” нь эвдэрч буй юм. Энэ бол хэлэнд, тэр тусмаа үгс-утгас нийлж, хоршиход хоосноос элдэв “дүрс” үүсэж, улмаар “дүрс” нь эргээд хоосонд шилждэгийг харуулж буй хэрэг юм. Энэ нь бас монгол хэлний “**хоршоо үг**”-ийн “бүтэж байгаа”, “бүтэхгүй байгаа” харьцангуй хоосон чанарын ялгаа заагийг харуулж буй юм. Тэгэхлээр “хоршоо үг” өөрөө бүтдэггүй, хүн-хэлийг хэрэглэгч түүнийг хэрэглэж, “ургуулж бүтээдэг гэсэн үг болно. Тавдугаар ноён хутагт Равжаа, “**Тунгалаг хөх огторгуй**” шүлэгтээ:

Тунгалаг хөх огторгуй хов хоосон байтал


Тунамал цагаан үүл нь хаа хаанаас цогцолно вэ?

Доторхи сэтгэлд дүрс нь үгүй байтал

Тов тодорхой элдвээр яагаад **ургана** вэ? гэсэн нь “нөхөр ба дайсан”-“нөхөр дайсан” гэдэг хоршоо, “газар ба тэнгэр”-“газар тэнгэр” гэдэг хоршоо, “гал ба ус”-“гал ус” гэдэг хоршоо, “газар ба ус”-“газар ус” гэдэг хоршоо, “газар ба дэлхий”-“газар дэлхий” гэдэг хоршоо, “газар ба орон”-“газар орон” гэдэг хоршоо, “газар ба шороо”-“газар шороо” гэдэг хоршоо үгийн учир, хоосон чанар, хэрэглээ, байгальлиг чанар, соёлыг танихад арга ба зарчмын нэгэн зам мөр болж байна гэж үзүүштэй.

Монгол хэлний хоршоо үгийн баялаг сан хөмрөгөөс яльгүй мөшгөөд харахад, хоршоо үгс бүтэхүйн даял тойрууд “**газар**” гэдэг үг нь “нутаг” гэдэг үгтэй утга ба орны ойрын “хамаатан” бөгөөд нэг нь нөгөөг “танимагц” ханьсан, сүлэлдэн хоршиж, хэрэглэх “үйлийн үр”-д орж, цэгцэрч явснаа, нөгөө тохиолдолд дахиад л салж, тэрхүү салаалсан шинэ даял тойруу, утгынхаа зам мөрөөр өвөрмөц тус тус “дүр”, “төрх”-өө хадгалан хэрэглэгддэг жамтай байна. Энэ бол синонимын эгнээ үүсгэх чадамжтай утга

ойролцоо ч бай, утга эсрэг ч бай хоршоо үгэнд хөдлөнгө, зогсонги буюу тогтвортой, тогтворгүй, шугаман, шугаман бус тийм шинж хадгалагдан байдгийг харуулж буй хэрэг юм. Үүнийг монгол хэлний “эрх” гэдэг “хөтлүүр үг” үгийн сангийн бүхий өөр нэгэн хоршоогийн “даял тойруу” дээр үзүүлье.



Жич: Хоршоо үгийн үүсэх бүтэх даял тойрууг дүрсэлсэн энэ зураг дээр “эрх” гэдэг хөтлүүр үгээр ойролцоо үг-утгын “хоршоонууд” үүсэж, эгнээ үүсэх байдал-дүр харагдана. Тэгэхдээ “эрх мэрх” гэдэг дуурайн хоршоо (акад. Б.Ринченийхээр) үг үүсэнгүүт сүлжээнд ончрол-сулрал гарч, улмаар “эрх үүрэг” гэж хоршингуут сүлжээ тасарч, ахин “үүрэг” гэдэг хөтлүүр үг давамгайлан, шинэ даял тойруу үүсэх бөгөөд “үүрэг даалгавар”, “үүрэг роль”, “үүрэг хариуцлага”, “үүрэг функц”, “үүрэг ажил” г.м.-ээр дахиад утга салаалан, “ажил” гэдэг “хөтлүүр”-тэй өөр “даял тойруу”-д орох жамтайг үзүүлж байгаа юм. Харин хэлийг хэрэглэгч тухайн хоршоо үгийн даял тойруугийн аль цэг дээрээс, ямар хоршоог авах нь тухайн хүний хэл – соёлын боловсрол, тэр үеийн ярих, бичих орчин, харилцааны нөхцөл, хэлийг хэрэглэх чадвараас шалтгаалан янз бүр байх, олон хувилбартай байх учиртай болно. Бас хэлийг хэрэглэгч нь хэлэхүйн цуваанд “хоршоо үг”-ийнхээ байр, дэс дарааллыг хөдөлгөн хувиргаж болдог.

НОМ ЗҮЙ

1. Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь, ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн, (Таван боть), Анхдугаар хэвлэл, Уб., 2008.
2. Д.Нацагдорж, Бүрэн зохиол-1, Оршил, удиртгал бичиж, тайлбар номзүй үйлдэн, хэвлэлд бэлтгэсэн Д.Цэдэв, Уб., 2006.

3. Б.Пүрэв-Очир, “Орон” хийгээд “оршихуй”, “даяар” хийгээд “даяаршихуй” (Үг, өгүүлбэрийн амьдрал, утга, эрчим соёл) ШУА-ийн Хэлзохиолын хүрээлэн, “Хэл зохиол судлал”, Уб., 2009, Т ом.2(34), дэвтэр 2., 9-15-р тал.
4. Б.Пүрэв-Очир, “Цэндийн Дамдинсүрэн судлал”-д нэмэрлэх дөрвөн дусал санал... МУБИС, МоСС-ийн “Монгол судлалын чуулган” ЭШБ, 2011, № 11(46), 11-20-р тал.
5. Б.Пүрэв-Очир, Нацагдоржийг найман хоршоогоор нь шинжихүй дор, “Судалбар эсээнүүд” ном, Уб., 2013.
6. Б.Пүрэв-Очир, “Хов”, “жив” хоёр хоршихын учир, “Монголын мэдээ” сонин, 2013.05.29-30, № 105, 107
7. Буянбаатар, Нүүдэл аж ахуй хийгээд нүүдэл соёл дахь байгальлиг шинжийг хайн шинжилсэн нь, МУБИС, МоСС-ийн “Монгол судлалын чуулган”, 2011, № 11(46), 230-240-р тал.
8. О.Лхагва, Мөнх тэнгэр ба хэл, сэтгэхүй, МУБИС-ийн МоСС-ийн “Монгол судлалын чуулган” ЭШБ., Уб., 2010, №8(43), 245-256-р тал.
9. О. Лхагва, Мөнх тэнгэрийн хүчин-орчлонгийн жам, МУИС-ийн Монгол хэл, соёлын сургууль, “Монгол: орон, соёл судлал” цуврал, Vol.2 (384), Уб., 2013, 13-33-р тал.
10. Ж.Бат-Ирээдүй, Монгол хэлний хоршоо үгийн товч толь бичиг, Уб., 2008.
11. Ж.Бат-Ирээдүй, Монгол хэлний хоршоо болон давтмал үг хэллэгийн сан. Уб., 2009.
12. Б.Жадамба, Б.Пүрэв-Очир, Л.Эрдэнэчимэг “Монгол хүмүүний дотоод ертөнцийн бүтэц, тогтолцоо ба монгол хэлний хоршоо үгийн шинж төрх”, МУБИС-ийн МоСС-ийн “Монгол судлалын чуулган” ЭШБ., № 12(47), Уб., 7-24-р тал.
13. Б.Пүрэв-Очир, А.Цог-Очир “Монгол хэлний хорших ёсны хэв шинж, бүрэлдүүлбэрийн талаар хийсэн зарим ажиглалт”, Mongolian studies, № 12, Korea, 2002.
14. Б.Ринчен, Монгол бичгийн хэлний зүй, Дөтгөөр дэвтэр, Өгүүлбэрийн зүй, Уб., 1967.
15. Ч.Пүрэвдорж, “Мөнх тэнгэр” бол монголчуудын оюун санааны нэгдмэл байдлын үндэс буюу, МУБИС-ийн МоСС-ийн “Монгол судлалын чуулган” ЭШБ., Уб., 2012, № 13(48) 155-165-р тал.
16. Д.Чингэлт, “Монгол хэлний хоршоо үгийн бүтцийн харьцааны тухай”. МУБИС-ийн МоСС-ийн ЭШБ., дэвтэр 9, 2011, № 11(46), 66-70-р тал.
17. Мөнхбуян, “Хэлний эх баялгийг хамгаалах асуудалд”, МУБИС-ийн МоСС-ийн ЭШБ., Уб., 2011, № 11(46), дэвтэр 8, 70-72-р тал.
18. Г.Оюунчимэг, Д.Маамын “Газар шороо” роман дахь “газар” гэсэн үг бүхий нэршсэн холбоо үг, МУИС, Монгол хэл, соёлын сургууль, “Монгол судлал” цуврал, 2008, боть ХХҮШ(294), 77-86-р тал.

SUMMARY

In this article, the word “*gazar/earth*” has been studied by analyzing the compound words within the Mongolian language. It shows that the compound words with either same meanings/synonyms or different meanings/antonyms have dynamic and static; linear and non linear features.